



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 02 сарын 12 өдөр

Дугаар 1/06

Арвайхээр

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.5 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг дарга, түүний Тамгын газрын 2018 оны үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажил үүргийн хуваарийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг 2019 оны 4 дүгээр сарын 1-ний дотор Монгол улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэхийг ажлын хэсэгт даалгасугай.

ДАРГА



Ц.ГАНБОЛД

012300026

D: My Doc. Tushaal. ZDTG

Аймгийн Засаг даргын Тамгын газрын
даргын 2019 оны ...02... дугаар сарын ...10... -ны
өдрийн ...11.06... дугаар тушаалын нэгдүгээр
хавсралт

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ТҮҮНИЙ ТАМГЫН ГАЗРЫН 2018 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙЖ,
ТАЙЛАНГ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: Ц.Ганболд (аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга)

Нарийн бичгийн дарга: Т.Үржинпүрэв (аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга)

Гишүүд: Н.Энхцэцэг (аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны
удирдлагын хэлтсийн дарга)

А.Отгонцэцэг (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн
хэлтсийн дарга)

Б.Сайнжаргал (аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн
бодлогын хэлтсийн дарга)

Э.Бадамгэрэл (аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн
захиргааны удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Ч.Батсуурь (аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны
удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн)


Ж.Бадамгарав (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт,
хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Р.Цэрэндэжид (аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн
сангийн хэлтсийн төсвийн мэргэжилтэн)

Л.Ишханд (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ,
үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн мэргэжилтэн)

Ц.Удвал (аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны
удирдлагын хэлтсийн мэргэжилтэн)

Ж.Отгонбаатар (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-
шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн мэргэжилтэн)



 Аймгийн Засаг даргын Тамгын газрын
 даргын 2019 оны ...06... дугаар сарын ...12... -ны
 өдрийн ...07/06... дугаар тушаалын хоёрдугаар
 хавсралт

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙЖ, ТАЙЛАНГ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН АЖИЛ ҮҮРГИЙН ХУВААРЬ

Аймгийн Засаг даргын Тамгын газрын бодлогын хэлтсийн дарга, мэргэжилтүүд дараах зохион байгуулалтаар 2018 оны жилийн эцсийн тайланг 2019 оны 2 дугаар сарын 18-наас 2019 оны 3 дугаар сарын 25-ны дотор үнэлж, дүгнэн Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.

1.Хэлтсийн ахлах мэргэжилтэн, мэргэжилтэн: Тайланг холбогдох хэлтэс (газар)-ээс нэгтгэн авч, мэдээллийг нягтлан шалгаж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн хэлтсийн даргад танилцуулна.

2.Хэлтсийн дарга: Тухайн тайланг нягтлан шалгаж, гарын үсэг зурж баталгаажуулна.

3.Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга: Тайланг уншиж мэдээллийг хянан, үнэлгээ өгнө. Хэрэв дутагдалтай үнэлгээтэй тохиолдолд бодлогын хэлтсүүдээс дахин тодруулга авч үнэлгээг гаргана.

4.Ажлын хэсгийн ахлагч: Тайланг уншиж, үнэлгээг 2018 оны 3 дугаар сарын 25-ны дотор эцэслэн баталгаажуулна.

Чанар: Тайлан, мэдээний чанар, үр дүнг сайжруулж, хугацаанд нь бодитой үнэлж тайлагнасан байна.

Үзүүлэлт		Хяналт шинжилгээ хийх албан хаагч	Хянаж, үнэлэх хэлтсийн дарга	Тайлан хүлээн авч хянах албан тушаалтан
Хугацаа		2019 оны 03 дугаар сарын 12-ны дотор	2019 оны 03 дугаар сарын 15-ний дотор	2019 оны 03 дугаар сарын 20-ны дотор
Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ	1.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт	1 дүгээр сарын 5-нд Unelgee.gov.mn цахим системд байршуулж, аймгийн Засаг даргын 2019 оны 10 дугаар албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.		
	2.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	2 дугаар сарын 1-нд Unelgee.gov.mn цахим системд байршуулж, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2019 оны 61 дүгээр албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.		
	3.Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэлийн биелэлт	Ж.Бадамгарав (ХОХБТХ)	Г.Баясгалан (ХОХБТХ-ийн дарга) 2 дугаар сарын 20-ны дотор хүргүүлнэ.	Т.Үржинпүрэв (ХШҮДАХ-ийн дарга)
	4.Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	Ч.Батсуурь (ТЗУХэлтэс)	Н.Энхцэцэг (ТЗУХ-ийн дарга) 2 дугаар сарын 20-ны дотор хүргүүлнэ.	Н.Энхцэцэг (ТЗУХ-ийн дарга)

	5.Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ (оны онцлох ажил)	Л.Ишханд (ХШУДАХ), Ж.Бадамгарав (ХОХБТХ)	Т.Үржинпүрэв (ХШУДАХ-ийн дарга)	Н.Энхцэцэг (ТЗУХ-ийн дарга)
Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	1.Засгийн газрын гишүүн аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт	Гэрээний үүргийн биелэлтийг холбогдох төрийн захиргааны төв байгууллагуудад хүргүүлсэн		
	2.Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын биелэлт	Э.Бадамгэрэл (ТЗУХэлтэс)	Н.Энхцэцэг (ТЗУХ-ийн дарга)	Н.Энхцэцэг (ТЗУХ-ийн дарга)
Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ	1.Байгууллагын ил тод байдлын үнэлгээ	Ц.Удвал (ТЗУХэлтэс)	Н.Энхцэцэг (ТЗУХ-ийн дарга)	Н.Энхцэцэг (ТЗУХ-ийн дарга)
	2.Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ	Р.Цэрэндэжид (СТСХ)	Д.Нэмэхбаяр (СТСХ-ийн дарга)	Т.Үржинпүрэв (ХШУДАХ-ийн дарга)
	3.Шударга байдлын түвшний үнэлгээ	А.Отгонцэцэг (ХЭЗХ)	А.Отгонцэцэг (ХЭЗХ-ийн дарга)	Т.Үржинпүрэв (ХШУДАХ-ийн дарга)
	4.Хэрэглэгчийн үнэлгээ	Сонгогдсон ТББ, Ж.Отгонбаатар (ХШУДАХ)	Т.Үржинпүрэв (ХШУДАХ-ийн дарга)	Ц.Ганболд (аймгийн ЗДТГ-ын дарга)
Нэгдсэн тайлан	Засаг даргын Тамгын газрын 2018 оны үйл ажиллагааны нэгдсэн тайлан, илтгэх хуудас	Дээрх мэргэжилтнүүд өөрсдийн хариуцсан бодлогын баримт бичгийн үр дүнгийн талаар товч тайлан бэлтгэнэ.	Хэлтсийн дарга нар хянах	Н.Энхцэцэг (ТЗУХ-ийн дарга), Т.Үржинпүрэв (ХШУДАХ-ийн дарга)